



# МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2016 оны 9 дүгээр  
сарын 27-ны өдөр

Дугаар 63

Улаанбаатар  
хот

## Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай

1. “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх санал тавьсан этгээдтэй хэлэлцээ хийх үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай:

Ахлагч:

-Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга

Гишүүд:

-Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга;

-Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга;

-Үндэсний хөгжлийн газрын дарга;

-Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга;

-Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга;

-Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах мэргэжилтэн;

-Иргэний нисэхийн ерөнхий газрын Агаарын тээврийн эдийн засгийн зохицуулалт, гадаад хамтын ажиллагааны газрын дарга;

-Иргэний нисэхийн ерөнхий газрын Үйлдвэрлэлийн нягтлан бодох бүртгэлийн албаны инженер-эдийн засагч;

-“Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл”-ийн захирал;

-Монголын агаарын тээвэрлэгчдийн холбооны тэргүүн (тохиролцсоноор).


Нарийн бичгийн  
дарга:

-Зам, тээврийн хөгжлийн яамны Агаарын  
тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах  
хэлтсийн дарга.

2. “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх санал тавьсан этгээдтэй хэлэлцээ хийх үүрэг бүхий Ажлын хэсгийн удирдамжийг хавсралт ёсоор баталсугай.

3. Хэлэлцээрийн явцыг тухай бүр Засгийн газарт танилцуулж байхыг Ажлын хэсэгт даалгасугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан “Ажлын хэсэг байгуулах тухай” Ерөнхий сайдын 2016 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн 80 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.




Монгол Улсын Ерөнхий сайд

Ж.ЭРДЭНЭБАТ

Зам, тээврийн хөгжлийн сайд

Д.ГАНБАТ



Ерөнхий сайдын 2016 оны 63 дугаар  
захирамжийн хавсралт

**“УЛААНБААТАР ХОТЫН ОЛОН УЛСЫН НИСЭХ ОНГОЦНЫ ШИНЭ БУУДЛЫН  
МЕНЕЖМЕНТ ТӨСӨЛ”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ САНАЛ ТАВЬСАН ЭТГЭЭДТЭЙ  
ХЭЛЭЛЦЭЭ ХИЙХ ҮҮРЭГ БҮХИЙ АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ**

“Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх санал тавьсан этгээдтэй хэлэлцээ хийхдээ дараах удирдамжийн дагуу ажиллана:

1. Төсөл хэрэгжүүлэх нөхцөл, шаардлага, шалгуур үзүүлэлтийг тогтоох;
2. Төслийн санал хүлээн авах болон бусад шаардлагатай баримт бичгийг боловсруулж батлах;
3. Төслийн саналын үнэлгээний журмыг хэрэгжүүлэх;
4. Төсөл хэрэгжүүлэх санал тавьсан этгээдэд төслийн саналаа ирүүлэх урилгыг санал хүлээн авах баримт бичгийн хамт хүргүүлэх;
5. Санал ирүүлсэн этгээдтэй хэлэлцээ хийж, дүгнэлт гаргах;
6. Санал ирүүлсэн этгээдтэй хэлэлцээ хийхдээ дараах арга хэмжээг авч ажиллана:
  - 1) төслийн саналын үнэлгээнд дэмжлэг үзүүлэх дэд ажлын хэсгийг холбогдох төрийн байгууллага, албан хаагчдын оролцоотойгоор байгуулж ажиллуулах;
  - 2) хэлэлцээ хийх ажиллагаанд санхүү, хууль, эрх зүйн болон шаардлагатай бусад зөвлөхийг татан оролцуулах;
  - 3) саналын үнэлгээ, хэлэлцээрийн нууцлалын баталгааг хангуулж, хэлэлцээрийн явцыг олон улсын тогтсон жишгийн дагуу баримтжуулах.
7. Хэлэлцээний явцын талаар Засгийн газарт тухай бүр танилцуулж, чиглэл авч ажиллах.